



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/390

Алтай хот

Газар эзэмших эрхийг дуусгавар болгож,
эрхийн гэрчилгээг хүчингүйд тооцох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд газар эзэмшиж байсан иргэний хүсэлтийн дагуу газар эзэмших эрхийг цуцалж, хавсралтаар баталж нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны А/214 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтын 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Газрын төлбөрийн ногдлоос хавсралтад дурдсан холбогдох хэсгийг хасаж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20~~22~~²⁰ оны ~~08~~⁰⁷ дугаар
сарын ~~21~~²⁰ ны өдрийн ~~1/390~~^{1/390} дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

НИЙТИЙН ЭЗЭМШИЛД ШИЛЖСЭН ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Иргэний нэр	Иргэний регистрийн дугаар	Эрхийн төрөл	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбарын хаяг	Газар эзэмшилтийн зориулалт
1	С.Дугарсүрэн	ДЮ55042574	Эзэмших	8208002200	240.0	Оргил баг	Үйлчилгээ (2111)

__оОо__